



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 24 едөр

Дугаар 8/15

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.5 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны эктопаразит болон эктопаразитаар дамжих халдвартын үүсгэгчийн тархалтыг тогтоох судалгааны ажлын Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт сонгогдсон цэгт газруудаас хачиг цуглуулах, хачгаар дамжих халдвартуудын үүсгэгчийн тархалтыг тогтоох тандалт судалгааг батлагдсан удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж ажиллахыг Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга (Д.Алтантогтох)-д үүрэг болгосугай.

2. Тандалт судалгааны ажлын зардал болох 43,416,250 (дөчин гурван сая дөрвөн зуун арван зургаан мянга хоёр зуун тавин) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АМГАЛАНБАЯР

